

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/044/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.15 № 52
танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, мөн тайлант онд урсгал засварын зардалд нэмж батлагдсан 50,000.0 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулан зарцуулсан,
2. Тайлант онд НДШ-ийн зардлаас цалингийн зардалд буюу зардлын бүлэг хооронд нийт 8,786.5 мянган төгрөг зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан,
3. Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг давхардуулж олгосонтой

612505317

D:\my doc \alban bichig\2026-A4.doc

холбоотойгоор тайлант онд шинээр 5,119.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,

4. Ээлжийн амралтын цалин, нэмэгдлийг зөрүүтэй тооцоож, 3,086.2 мянган төгрөг илүү олгосон,
5. Орон нутгийн төсвөөс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд олгосон санхүүжилтийн хэмнэлт 4,502.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1-д "Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна", 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 2,404,390.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой 409,822.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зардлыг зүйл ангиар зарцуулж, хэмнэлтийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Цахим анги байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн үнийн 84,997.0 мянган төгрөгийг ОРАЖСЕБС/011/001 гэрээгээр тохирсон хуваарийн дагуу төлж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 38,956.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийг төлөвлөгөөг 6 зорилт 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| | /төгрөгөөр/ | |
|--|--------------------------------|--------------------------------|
| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>284,934,899.82</u> | <u>301,466,241.39</u> |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 105,055,163.67 | 70,849,059.89 |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 105,055,163.67 | 70,849,059.89 |
| Төгрөг | 105,055,163.67 | 70,849,059.89 |
| Төрийн сангийн харилцах | 105,055,163.67 | 70,849,059.89 |
| АВЛАГА | 2,584,418.71 | 7,704,218.71 |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,584,418.71 | 7,704,218.71 |
| БАРАА МАТЕРИАЛ | 177,295,317.44 | 222,912,962.79 |
| Түүхий эд материал | 175,116,642.44 | 218,142,262.79 |
| Тусгай зориулалттай материал | 175,116,642.44 | 218,142,262.79 |
| Хангамжийн материал | 1,695,700.00 | 1,781,400.00 |
| Хүнсний материал | 1,695,700.00 | 1,781,400.00 |
| Биологийн хөрөнгө | 482,975.00 | 2,989,300.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>3,300,768,441.29</u> | <u>3,163,890,483.31</u> |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,300,768,441.29 | 3,163,890,483.31 |
| Биет хөрөнгө | 3,262,860,441.29 | 3,125,982,483.31 |
| Барилга, байгууламж, орон сууц | 2,988,639,211.19 | 2,988,639,211.19 |
| Хуримтлагдсан элэгдэл | -461,489,367.34 | -566,978,082.46 |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 525,122,947.42 | 560,324,150.69 |
| Хуримтлагдсан элэгдэл | -208,680,042.43 | -247,240,404.68 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 575,328,286.62 | 574,900,070.15 |
| Хуримтлагдсан элэгдэл | -237,223,390.12 | -293,488,762.05 |
| Бусад үндсэн хөрөнгө | 155,086,839.68 | 199,158,834.68 |
| Хуримтлагдсан элэгдэл | -73,924,043.73 | -89,332,534.21 |
| Биет бус хөрөнгө | 37,908,000.00 | 37,908,000.00 |
| Програм хангамж | 250,000.00 | 250,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | -250,000.00 | -250,000.00 |
| Бусад биет бус хөрөнгө | 37,908,000.00 | 37,908,000.00 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>3,585,703,341.11</u> | <u>3,465,356,724.70</u> |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>75,300,210.00</u> | <u>41,875,327.28</u> |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 75,300,210.00 | 41,875,327.28 |
| Өглөг | 75,300,210.00 | 41,875,327.28 |
| Бусад өглөг | 75,300,210.00 | 41,875,327.28 |
| Байгууллагад төлөх өглөг | 75,300,210.00 | 41,875,327.28 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>3,510,403,131.11</u> | <u>3,423,481,397.42</u> |
| Засгийн газрын хувь оролцоо | 3,510,403,131.11 | 3,423,481,397.42 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 595,526,061.12 | 595,526,061.12 |
| Өмч: - төрийн | 595,526,061.12 | 595,526,061.12 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,356,351,724.13 | 1,269,429,990.44 |
| Өмнөх үеийн үр дүн | 1,356,351,724.13 | 1,356,351,724.13 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | -86,921,733.69 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,558,525,345.86 | 1,558,525,345.86 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>3,585,703,341.11</u> | <u>3,465,356,724.70</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|--|-------------------------|-------------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,970,557,220.92 | 3,309,748,651.03 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 511,834,920.92 | 495,535,951.03 |
| Нийтлэг татварын бус орлого | 511,834,920.92 | 495,535,951.03 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 511,834,920.92 | 495,535,951.03 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,161,615.00 | 5,018,000.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 137,509,510.00 | 183,079,728.28 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 350,798,844.92 | 100,336,710.40 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 11,364,951.00 | 207,101,512.35 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,458,722,300.00 | 2,814,212,700.00 |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 2,079,042,500.00 | 2,404,390,500.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,079,042,500.00 | 2,404,390,500.00 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 379,679,800.00 | 409,822,200.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 379,679,800.00 | 409,822,200.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,742,876,631.31 | 3,396,561,801.37 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,742,876,631.31 | 3,396,561,801.37 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,672,257,476.32 | 3,324,413,914.60 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,673,338,144.78 | 2,055,249,158.06 |
| Цалин | 958,200,834.43 | 1,010,090,073.05 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 715,137,310.35 | 1,045,159,085.01 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 222,579,800.00 | 266,462,300.00 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 186,967,000.00 | 223,828,100.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 35,612,800.00 | 42,634,200.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 347,780,003.01 | 353,440,688.23 |
| Гэрэл, цахилгаан | 16,702,916.30 | 22,478,728.23 |
| Түлш, халаалт | 322,522,112.00 | 321,733,511.00 |
| Цэвэр, бохир ус | 8,554,974.71 | 9,228,449.00 |
| Нормативт зардал | 102,572,165.00 | 97,400,950.00 |
| Хоол, хүнс | 102,572,165.00 | 97,400,950.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 9,640,000.00 | 219,529,092.00 |
| Урсгал засвар | 9,640,000.00 | 219,529,092.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 47,889,493.88 | 33,439,731.28 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 4,530,000.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 47,889,493.88 | 28,909,731.28 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 268,457,869.65 | 298,891,995.03 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 51,670,370.00 | 50,026,950.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,651,200.00 | 11,758,960.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 203,136,299.65 | 237,106,085.03 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 70,619,154.99 | 72,147,886.77 |
| Бусад урсгал шилжүүлэг | 68,876,990.00 | 69,965,575.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 52,658,290.00 | 69,965,575.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,218,700.00 | 0.00 |

| | | |
|---|------------------------------|------------------------------|
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,742,164.99 | 2,182,311.77 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,742,164.99 | 2,182,311.77 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>227,680,589.61</u> | <u>-86,813,150.34</u> |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 108,583.35 |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.00 | 108,583.35 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 0.00 | -108,583.35 |
| НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>227,680,589.61</u> | <u>-86,921,733.69</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|--|--------------------------------|--------------------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>2,608,393,425.00</u> | <u>3,002,310,428.28</u> |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 149,671,125.00 | 188,097,728.28 |
| Нийтлэг татварын бус орлого | 149,671,125.00 | 188,097,728.28 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 149,671,125.00 | 188,097,728.28 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,161,615.00 | 5,018,000.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 137,509,510.00 | 183,079,728.28 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,458,722,300.00 | 2,814,212,700.00 |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 2,079,042,500.00 | 2,404,390,500.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,079,042,500.00 | 2,404,390,500.00 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 379,679,800.00 | 409,822,200.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 379,679,800.00 | 409,822,200.00 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>2,563,271,365.66</u> | <u>3,036,516,532.06</u> |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,563,271,365.66 | 3,036,516,532.06 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,495,327,400.67 | 2,961,862,320.29 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,673,338,144.78 | 2,060,368,958.06 |
| Цалин | 958,200,834.43 | 1,015,209,873.05 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 715,137,310.35 | 1,045,159,085.01 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 222,579,800.00 | 266,462,300.00 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 186,967,000.00 | 223,828,100.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 35,612,800.00 | 42,634,200.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 367,937,635.01 | 353,440,688.23 |
| Гэрэл, цахилгаан | 16,702,916.30 | 22,478,728.23 |
| Түлш, халаалт | 342,679,744.00 | 321,733,511.00 |
| Цэвэр, бохир ус | 8,554,974.71 | 9,228,449.00 |
| Нормативт зардал | 101,671,480.00 | 97,486,650.00 |
| Хоол, хүнс | 101,671,480.00 | 97,486,650.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 10,000,000.00 | 54,199,200.00 |
| Урсгал засвар | 10,000,000.00 | 54,199,200.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,975,485.88 | 34,304,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 6,167,000.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,975,485.88 | 28,137,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 98,824,855.00 | 95,600,524.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 83,853,655.00 | 85,272,204.00 |

| | | |
|---|------------------------------|------------------------------|
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,971,200.00 | 10,328,320.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 67,943,964.99 | 74,654,211.77 |
| Бусад урсгал шилжүүлэг | 66,201,800.00 | 72,471,900.00 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,983,100.00 | 72,471,900.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,218,700.00 | 0.00 |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,742,164.99 | 2,182,311.77 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,742,164.99 | 2,182,311.77 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>45,122,059.34</u> | <u>-34,206,103.78</u> |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 20,061,300.00 | 0.00 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,061,300.00 | 0.00 |
| Дотоод эх үүсвэрээр | 20,061,300.00 | 0.00 |
| Тоног төхөөрөмж | 20,061,300.00 | 0.00 |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-20,061,300.00</u> | <u>0.00</u> |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 25,060,759.34 | -34,206,103.78 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 79,994,404.33 | 105,055,163.67 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 105,055,163.67 | 70,849,059.89 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--|---------------------------------|-------------------------|-------------------------|---|
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 595,526,061.12 | 1,558,525,345.86 | 1,128,671,134.52 | 3,282,722,541.50 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 595,526,061.12 | 1,558,525,345.86 | 1,128,671,134.52 | 3,282,722,541.50 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 227,680,589.61 | 227,680,589.61 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 595,526,061.12 | 1,558,525,345.86 | 1,356,351,724.13 | 3,510,403,131.11 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 595,526,061.12 | 1,558,525,345.86 | 1,356,351,724.13 | 3,510,403,131.11 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 595,526,061.12 | 1,558,525,345.86 | 1,356,351,724.13 | 3,510,403,131.11 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -86,921,733.69 | -86,921,733.69 |
| 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 595,526,061.12 | 1,558,525,345.86 | 1,269,429,990.44 | 3,423,481,397.42 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|--|-------------------------|-------------------------|-----------------------|-------------|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,822,799,700.00 | 2,626,694,332.06 | 196,105,367.94 | 93.1 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,822,799,700.00 | 2,626,694,332.06 | 196,105,367.94 | 93.1 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,741,989,300.00 | 2,554,222,432.06 | 187,766,867.94 | 93.2 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,193,649,500.00 | 2,060,368,958.06 | 133,280,541.94 | 93.9 |
| Цалин | 1,246,644,900.00 | 1,015,209,873.05 | 231,435,026.95 | 81.4 |

| | | | | |
|--|-------------------------|-------------------------|-----------------------|-------------|
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 947,004,600.00 | 1,045,159,085.01 | -98,154,485.01 | 110.4 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 274,206,100.00 | 266,462,300.00 | 7,743,800.00 | 97.2 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 230,333,100.00 | 223,828,100.00 | 6,505,000.00 | 97.2 |
| Тэтгэмжийн даатгал | 43,873,000.00 | 42,634,200.00 | 1,238,800.00 | 97.2 |
| Нормативт зардал | 104,174,900.00 | 97,486,650.00 | 6,688,250.00 | 93.6 |
| Хоол, хүнс | 104,174,900.00 | 97,486,650.00 | 6,688,250.00 | 93.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 36,511,900.00 | 34,304,000.00 | 2,207,900.00 | 94.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,527,100.00 | 6,167,000.00 | 1,360,100.00 | 81.9 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 28,984,800.00 | 28,137,000.00 | 847,800.00 | 97.1 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 133,446,900.00 | 95,600,524.00 | 37,846,376.00 | 71.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 123,077,400.00 | 85,272,204.00 | 37,805,196.00 | 69.3 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,369,500.00 | 10,328,320.00 | 41,180.00 | 99.6 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 80,810,400.00 | 72,471,900.00 | 8,338,500.00 | 89.7 |
| Бусад урсгал шилжүүлэг | 80,810,400.00 | 72,471,900.00 | 8,338,500.00 | 89.7 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 80,810,400.00 | 72,471,900.00 | 8,338,500.00 | 89.7 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,232,621,900.00 | 3,105,183,280.18 | 127,438,619.82 | 96.1 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,438,159,500.00 | 2,404,390,500.00 | 33,769,000.00 | 98.6 |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,438,159,500.00 | 2,404,390,500.00 | 33,769,000.00 | 98.6 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |
| Орон нутгийн төсвөөс | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 384,640,200.00 | 293,152,891.95 | 91,487,308.05 | 76.2 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,890,000.00 | 5,018,000.00 | 872,000.00 | 85.2 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 273,739,900.00 | 183,079,728.28 | 90,660,171.72 | 66.9 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 105,010,300.00 | 105,055,163.67 | -44,863.67 | 100.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 105,055,163.67 | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 70,849,059.89 | | |

2.6 Аудит хийсэн орон нутгийн дансны төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|--|-----------------------|-----------------------|---------------------|-------------|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 355,622,200.00 | 353,440,688.23 | 2,181,511.77 | 99.4 |

| | | | | |
|--|-----------------------|-----------------------|---------------------|--------------|
| Гэрэл, цахилгаан | 23,700,100.00 | 22,478,728.23 | 1,221,371.77 | 94.8 |
| Түлш, халаалт | 322,522,100.00 | 321,733,511.00 | 788,589.00 | 99.8 |
| Цэвэр, бохир ус | 9,400,000.00 | 9,228,449.00 | 171,551.00 | 98.2 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 54,200,000.00 | 54,199,200.00 | 800.00 | 100.0 |
| Урсгал засвар | 54,200,000.00 | 54,199,200.00 | 800.00 | 100.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |
| Орон нутгийн төсвөөс | 409,822,200.00 | 407,639,888.23 | 2,182,311.77 | 99.5 |

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 35,486.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 35,486.8 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Тайлант онд туслах үйл ажиллагааны орлогыг 35,486.8 мянган төгрөгөөр илүү бүртгэж тус дүнгээр цалингийн зардлыг нэмэгдүүлж тайлагнасан байна.

Аудитаар нийт 71,495.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 3,086.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 4,502.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 50,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцуулах албан шаардлага, 13,906.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Цалингийн тооцоог алдаатай хийсэн, жирэмсэн, амаржсаны амралттай албан хаагчийн ээлжийн амралтын цалинг нийт 3,086.2 мянган төгрөгөөр илүү бодож олгосонд 2 төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Орон нутгийн төсвөөс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд олгосон санхүүжилтийн хэмнэлт 4,502.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлээгүйд албан шаардлага өгөв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг илүү олгосноос шалтгаалж 5,119.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үүссэн авлагыг нэн даруй барагдуулж, цаашид авлага үүсгэхгүй ажиллах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2 ажилтны ажил мэргэжлийн ангиллын кодыг зөрүүтэй мэдээлснээр ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг алдаатай ноогдуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2-д “Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ”, 32.2.2-д “орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 2 ажилтны ажил мэргэжлийн ангиллыг холбогдох ангиллын дагуу тайлагнах

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 8,786.5 мянган төгрөг зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн сар, улирлын хуваарийг баримталж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахгүй байх.

Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | | 1 | | |

Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орхон аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль | 1 | 35,486.8 | | | 1 | 35,486.8 | 1 | 35,486.8 | | | | |
| Дүн | 1 | 35,486.8 | | | 1 | 35,486.8 | 1 | 35,486.8 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|----------------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орхон аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль | 1 | 706.4 | 1 | 706.4 | | | | | | | | |
| | 1 | 2,379.8 | 1 | 2,379.8 | | | | | | | | |
| | 1 | 4,502.7 | | | 1 | 4,502.7 | | | | | | |
| | 1 | 50,000.0 | | | | | | | 1 | 2 | | |
| | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| | 1 | 8,786.5 | | | | | 1 | 8,786.5 | | | | |
| | 1 | 5,119.8 | | | | | 1 | 5,119.8 | | | | |
| Дүн | 7 | 71,495.2 | 2 | 3,086.2 | 1 | 4,502.7 | 3 | 13,906.3 | 1 | 2 | | |